



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Г Нийтэд санал болгон гаргаж буй үнэт Г  
цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инвекор ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 227 /хоёр зуун хорин долоон/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 71,727,918 /далан нэгэн сая долоон зуун хорин долоон мянга есөн зуун арван найм/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Инвекор ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 227 /хоёр зуун хорин долоо/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 60,968,730 /жаран сая есөн зуун жаран найман мянга долоон зуун гучин/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-ийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 1,613,878 /нэг сая зургаан зуун арван гурван мянга найман зуун далан найман/ ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар тус бүрийн үнийг 1,550 /нэг мянга таван зуун тавь/ - 1,650 /нэг мянга зургаан зуун тавь/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Инвекор ББСБ” ХХК /Д.Баясгалан/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 9,145,310 /есөн сая нэг зуун дөчин таван мянга гурван зуун арав/ ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар тус бүрийн үнийг 1,650 /нэг мянга зургаан зуун тавь/-1,750 /нэг мянга долоон зуун тавь/ төгрөгөөр “Инвекор ББСБ” ХХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын 3, 4-т заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааг 100 /нэг зуу/ хувь анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд худалдагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүйд тооцохыг “Инвекор ББСБ” ХХК /Д.Баясгалан/-д мэдэгдсүгэй.

6. Энэ тогтоолын 2-т заасан 60,968,730 /жаран сая есөн зуун жаран найман мянга долоон зуун гуч/ ширхэг хувьцаанаас 7,172,791 /долоон сая нэг зуун далан хоёр мянга



долоон зуун ерэн нэг/ ширхэг хувьцааг Хороо хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг олгосоноос хойш 12 сарын хугацаанд дахин нэмж гаргах хүртэлх хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/, энэ тогтоолын 3-д заасан үнээр олон нийтэд нэмж гаргахыг “Инвескор ББСБ” ХХК /Д.Баясгалан/-д тус тус үүрэг болгосугай.

7. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 2, 4-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

9. Энэ тогтоолын 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК /Т.Даваажав/-д анхааруулсугай.

10. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үнэт цаасны үнэ ханш хэт савлах, буурах, жижиг хөрөнгө оруулагчийн эрх ашиг зөрчигдөх эрсдэлээс сэргийлсэн арга хэмжээг авч, зах зээл үүсгэгчийн үүрэг гүйцэтгэхийг “Инвескор ББСБ” ХХК /Д.Баясгалан/, “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК /Т.Даваажав/-д тус тус даалгасугай.

11. “Инвескор ББСБ” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Инвескор ББСБ” ХХК /Д.Баясгалан/-д үүрэг болгосугай.

12. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК /Т.Даваажав/, “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН /Ж.Майзориг/, “Гэрэгэ Эстимэйт” ХХК /Д.Ганбаатар/, “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/-д тус тус анхааруулсугай.

13. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН